



# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

---

ТӨРИЙН ӨМЧИТ АЖ АХУЙН НЭГЖ

АУДИТЫН КОД: ТӨА-2022/06/-НА-СТА-ТӨА

ТӨВ АЗЗА ТӨХК-ИЙН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН  
АУДИТЫН ТАЙЛАН

---

Зуунмод 2022 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: [khishigjargalts@audit.gov.mn](mailto:khishigjargalts@audit.gov.mn)

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: [amarjargalo@audit.gov.mn](mailto:amarjargalo@audit.gov.mn)

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Уваа Уул Аудит ХХК

Захирал: Ч.Мөнхтуяа

Цахим хаяг: [uwaauul.audit@gmail.com](mailto:uwaauul.audit@gmail.com)

## Агуулга

1. Аудитын санал дүгнэлт .....	4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан .....	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	6
2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан .....	7
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан .....	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	9
2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл .....	10
3. Аудитын тайлан .....	11
3.1 Ерөнхий зүйл .....	11
3.2 Дотоод хяналт .....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	11
3.4 Материаллаг байдал .....	11
4. Санхүүгийн тайлангийн тодруулга .....	12
4.1 Байгууллагын үйл ажиллагаа .....	12
4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин .....	12
4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого .....	12
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	13
5.1 Шилэн дансны мэдээлэл .....	13
6. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	14
7. Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	14
8. Аудитын илрүүлэлт .....	15
8.4 Зөвлөмж .....	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	16

**Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ААНОАТ	Аж ахуй нэгжийн орлогын албан татвар
ЗГХЭГ	Засгийн газрын хэрэг эрхлэх газар
ЗТХЯ	Зам, тээвэр хөгжлийн яам
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ТБОНӨХБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай



**ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум

Утас: 70272248, Факс: 70272582 И-мэйл: tuv@audit.gov.mn

2022.03.15 № 01/211  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Төв АЗЗА ТӨХК-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Төв АЗЗА ТӨХК-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Аудитын гол асуудлууд**

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудалд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй зүйлсийг тодруулсан ба тэдгээрийг аудитын хүрээнд нэгтгэсэн байдлаар авч үзсэн болно.

Тайлант онд орлогыг 1,902.5 сая төгрөгөөр, зардлыг 1,865.0 сая төгрөг, ашгийг 33.7 сая төгрөг байхаар баталсан байна. Гүйцэтгэлээр 2,009.5 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 1,996.4 сая төгрөгийн зардал гарган, 34.3 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

**Бусад мэдээлэл**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилтын хүрээнд 3 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 98.0 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

**Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

19020418

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	<b>ХӨРӨНГӨ</b>		
1.1	<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	96,806,338.45	28,032,365.18
1.1.2	Дансны авлага	0.00	314,788,002.40
1.1.3	Татвар, НДШ—ийн авлага	1,763,163.64	0.00
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	11,510,000.00	0.00
1.1.6	Бараа материал	133,120,796.82	131,374,972.20
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	16,813,885.00	16,116,117.00
1.1.10	Дуусаагүй үйлдвэрлэл	359,653,052.72	328,543,252.72
1.1.11	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>619,667,236.63</b>	<b>818,854,709.49</b>
1.2	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		
1.2.1	Үндсэн хөрөнгө	679,239,465.22	632,927,469.77
1.2.2	Биет бус хөрөнгө	556,913,000.00	556,913,000.00
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт		
1.2.10	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>1,254,152,465.22</b>	<b>1,189,840,469.77</b>
1.3	<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>1,873,819,701.85</b>	<b>2,008,695,179.26</b>
2.1	<b>Өр төлбөр</b>		
2.1.1	<b>Богино хугацаат өр төлбөр</b>		
2.1.1.1	Дансны өглөг	101,046,050.28	451,187,278.18
2.1.1.2	Цалингийн өглөг	2,317,212.00	0.00
2.1.1.3	Татварын өр	308,588,551.87	84,285,860.17
2.1.1.4	НДШ-н өглөг	40,000,000.00	17,012,648.81
2.1.1.13	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>451,951,814.15</b>	<b>552,485,787.16</b>
2.2	<b>Өр төлбөрийн дүн</b>	<b>451,951,814.15</b>	<b>552,485,787.16</b>
	<b>ЭЗДИЙН ӨМЧ</b>		
2.3	<b>Өмч</b>		
2.3.1	-төрийн	893,549,171.16	893,549,171.16
2.3.2	-хувийн		
2.3.3	-хувьцаат		
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	759,175,381.32	759,175,381.32
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	556,913,000.00	556,913,000.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(787,769,664.78)	(753,428,160.37)
2.3.11	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>1,421,867,887.70</b>	<b>1,456,209,392.11</b>
2.4	<b>Өр төлбөр ба эздийн өмчийн дүн</b>	<b>1,873,819,701.85</b>	<b>2,008,695,179.26</b>

## 2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	3,004,825,955.00	2,009,534,755.91
2	Борлуулалтын өртөг	2,836,801,863.67	1,802,888,800.79
3	<b>Нийт ашиг ( алдагдал)</b>	<b>168,024,091.34</b>	<b>206,645,955.12</b>
4	Түрээсийн орлого	18,946,441.82	25,209,090.91
10	Ерөнхий ба удирдлагын зардал	177,236,318.62	193,499,348.91
11	Санхүүгийн зардал	208,199.99	198,470.00
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз	109,090.91	0.00
18	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>9,635,105.45</b>	<b>38,157,227.12</b>
19	Орлогын татварын зардал	963,510.55	3,815,722.71
20	<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>8,671,594.90</b>	<b>34,341,504.41</b>
22	<b>Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал)</b>	<b>8,671,594.90</b>	<b>34,341,504.41</b>
23	<b>Бусад дэлгэрэнгүй орлого</b>		
24	<b>Орлогын нийт дүн</b>	<b>8,671,594.90</b>	<b>34,341,504.41</b>
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

### 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
<b>2019 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл</b>	<b>893,549,171.16</b>	<b>759,175,381.32</b>	<b>556,913,000.00</b>	<b>(796,441,259.68)</b>	<b>1,431,196,292.80</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					
<b>Залруулсан үлдэгдэл</b>					
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				8,671,594.00	8,671,594.00
Бусад дэлгэрэнгүй орлого					
<b>2020 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл</b>	<b>893,549,171.16</b>	<b>759,175,381.32</b>	<b>556,913,000.00</b>	<b>(787,769,664.78)</b>	<b>1,421,867,887.70</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					
<b>Залруулсан үлдэгдэл</b>					
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				34,341,504.41	34,341,504.41
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн					
<b>2021 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл</b>	<b>893,549,171.16</b>	<b>759,175,381.32</b>	<b>556,913,000.00</b>	<b>(753,428,160.37)</b>	<b>1,456,209,392.11</b>

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн</b>	<b>3,392,169,545.24</b>	<b>1,850,736,551.25</b>
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	3,358,003,427.00	1,732,923,460.00
	Буцаан авсан албан татвар		47,957,660.37
1.1.6	Бусад мөнгөн орлого	34,166,118.24	69,855,430.88
<b>1.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн</b>	<b>3,416,192,501.81</b>	<b>1,918,643,364.52</b>
1.2.1	Ажиллагчдад төлсөн	487,220,674.39	433,651,378.00
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	86,107,018.83	151,810,710.71
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	1,468,257,940.76	512,184,862.00
	Ашиглалтын зардалд төлсөн	26,813,519.52	24,863,889.46
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	488,766,429.47	227,109,166.00
	Татварын байгууллагад төлсөн	290,782,885.85	407,280,464.35
	Даатгалын төлбөрт төлсөн	3,799,915.00	3,905,676.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	564,444,117.90	157,837,218.00
<b>1.3</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(24,022,956.57)</b>	<b>(67,906,813.27)</b>
<b>2</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>2.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн</b>	<b>120,000.00</b>	
2.1.6	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	120,000.00	
<b>2.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн</b>	<b>4,639,400.00</b>	
2.2.2	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	4,639,400.00	
<b>2.3</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(4,639,400.00)</b>	
<b>3</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>3.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн</b>	<b>1,770,000.00</b>	867,160.00
3.1.4	Төлсөн ногдол ашиг	1,770,000.00	867,160.00
<b>3.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн</b>		
3.2.5	Валютын ханшийн зөрүү		
<b>3.3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(1,770,000.00)</b>	(867,160.00)
<b>4.1</b>	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>(30,312,356.57)</b>	<b>(68,773,973.27)</b>
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>127,118,695.02</b>	<b>96,806,338.45</b>
<b>6</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>96,806,338.45</b>	<b>28,032,365.18</b>

Төв АЗЗА төрийн өмчит хувьцаат компанийн  
2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

**2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл**

/мянган төгрөгөөр/

д/д	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2020 оны гүйцэтгэл	2021 оны			
				төлөвлөгөө	гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	<b>Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт</b>	мян.төг	<b>3,004,934.6</b>	<b>1,889,466.9</b>	<b>2,034,743.9</b>	(145,277.0)	107.7
	Улсын чанартай авто зам засвар, арчлалтын ажил	мян.төг	1,842,311.8	1,539,466.9	1,551,409.6	(11,942.7)	100.8
	Орон нутгийн чанартай авто зам засвар арчлалтын ажил	мян.төг	1,181,569.3	350,000.0	458,125.2	(108,125.2)	130.9
	<b>Нийт орлого</b>	мян.төг	<b>3,023,881.1</b>	<b>1,902,530.5</b>	<b>2,009,534.8</b>	(107,004.3)	105.6
	Түрээсийн орлого	мян.төг	18,627.3	13,063.6	25,209.1	(12,145.5)	193.0
2	<b>Нийт зардал</b>	мян.төг	<b>3,014,245.9</b>	<b>1,865,041.8</b>	<b>1,996,388.2</b>	(131,346.4)	107.0
	Үүнээс: удирдлагын зардал	мян.төг	177,236.3	244,011.8	193,499.3	50,512.5	79.3
3	<b>Татварын өмнөх ашиг/ алдагдал/</b>	мян.төг	<b>9,635.1</b>	<b>37,488.7</b>	<b>38,157.2</b>	(668.5)	101.8
	Цэвэр ашиг алдагдал	мян.төг	8,671.6	33,739.9	34,341.5	(601.7)	101.8
4	<b>Төсвийн төлбөр</b>	мян.төг	<b>393,705.9</b>	<b>316,527.7</b>		316,527.7	-
	Орлогын татвар	мян.төг	1,575.3	3,748.8	3,815.7	(66.9)	101.8
	НӨАТ	мян.төг	228,432.8	171,769.7	378,380.5	(206,610.8)	220.3
	Хувь хүний орлогын албан татвар	мян.төг	46,973.0	38,044.9	27,405.5	10,639.4	72.0
	Үл хөдлөх хөрөнгийн татвар	мян.төг	5,228.4	5,228.4		5,228.4	-
	НДШ	мян.төг	101,107.0	92,874.9	151,810.7	(58,935.8)	163.5
	Тээврийн хэрэгслийн татвар, бусад татвар	мян.төг	8,619.4	1,606.8	1,494.5	112.3	93.0
Төрийн өмчийн ноогдол ашиг	мян.төг	1,770.0	1,254.1	867.2	386.9	69.1	
5	Нийт ажиллагсдын тоо	Хүн	36.0	44.0	32.0	12.0	72.7
6	Нийт цалингийн сан	мян.төг	555,069.3	580,449.2	485,064.6	95,384.6	83.6
7	Нэг ажиллагчийн дундаж цалин	мян.төг	1,284.9	1,099.3	1,263.2	(163.8)	114.9
8	Борлуулалтын нэг төгрөгт ногдох зардал	төг	1.0	1.0	1.0	0.0	98.7
9	<b>Нийт авлага</b>	мян.төг	<b>13,273.2</b>	<b>482,790.7</b>	<b>314,788.0</b>	<b>168,002.7</b>	<b>65.2</b>
	Үүнээс: найдваргүй	мян.төг	-			-	-
10	Нийт өглөг	мян.төг	451,951.8	304,807.4	552,485.8	(247,678.4)	181.3
	Үүнээс: богино хугацаат өглөг	мян.төг	451,951.8	304,807.4	552,485.8	(247,678.4)	181.3
11	Хөрөнгө оруулалт	мян.төг	4,639.4	80,000.0	-	80,000.0	-

### **3. Аудитын тайлан**

#### **3.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Төв АЗЗА ТӨХК-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд компанийн дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудалд аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад үндсэн хөрөнгө, бараа материалын данстай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 02 дугаар сарын 15-наас 2022 оны 03 дугаар сарын 15-ны хооронд Уваа уул Аудит ХХК-ийн аудитор Б.Буяндэлгэр, аудиторын туслах Э.Номинчулуун, Г.Сампилмаа нар гүйцэтгэж, чанар хяналтыг захирал Ч.Мөнхтуяа хэрэгжүүлсэн.

Төв АЗЗА ТӨХК-ын 2021 оны санхүүгийн тайлангаа Уваа уул аудит ХХК-д 2022 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн 1/5 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2 Дотоод хяналт**

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тус байгууллага нь дотоод аудитын нэгжгүй, тайлант онд Зам, тээвэр хөгжлийн яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар, ТӨБЗГ-ын хууль эрх зүй, хяналт, дотоод аудитын хэлтсээс шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Төв АЗЗА ТӨХК нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

#### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлын 3,015.2 сая төгрөгөөс 1 хувиар буюу 30.1 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг тооцох суурь үзүүлэлт, эрсдэлийн үнэлгээ өөрчлөгдсөн тул материаллаг байдлын түвшинг 2021 оны орлогын дэлгэрэнгүй

тайлангийн нийт зардлын дүн 2,000.4 сая төгрөгөөс 1 хувиар буюу 20.0 сая төгрөгөөр тогтоолоо.

#### 4. Санхүүгийн тайлангийн тодруулга

##### 4.1 Байгууллагын үйл ажиллагаа

Төв АЗЗА ТӨХК-ын зорилго нь “Улсын чанартай авто замын засвар арчлалт, шугамуудын хэсгүүдийг шуурхай удирдлагаар хангаж, хариуцсан авто зам, замын байгууламжийн бүрэн бүтэн байдалд хяналт тавьж, гарсан эвдрэл гэмтлийг арилгах ажлыг зохион байгуулж, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг саадгүй нэвтрүүлэх, нөхцөлийг бүрдүүлэх”-д оршино

Төв АЗЗА ТӨХК-ын дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ Үүнд:

- Авто зам, замын байгууламжийг барих, засварлах;
- Хатуу хучилттай зам барих;
- Хатуу болон хайрган хучилттай зам засварлах;
- Төмөр бетон, ган төмөр, модон гүүр засварлах;
- Зам, замын байгууламжид хамаарах талбай барих, засварлах;
- Үерийн хамгаалалтын далан барих;
- Тавилан барих, засварлах;

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд төрийн ТӨХК гэсэн статустай байна. Өмчийн 100.0 хувийг ТӨБЗГ эзэмшиж байна.

##### 4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

Төв АЗЗА ТӨХК-ийн төлөөлөн удирдах зөвлөл нь хуульд заасны дагуу Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар 3, төрийн төлөөлөл 3, хараат бус 3, нарийн бичиг 1, нийт 10 гишүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлыг 2 удаа зохион байгуулж 2022 оны төлөвлөгөө, зохион байгуулалтын арга хэмжээ зэрэг асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэсэн байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалинд 18.0 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль;
- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай”;
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны журмыг сонгоход баримтлах босго үнэ шинэчлэн батлах тухай”

##### 4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Төв АЗЗА ТӨХК-ын тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	96,806,338.5	28,032,365.2	(68,773,973.3)
Авлага	13,273,163.6	314,788,002.4	301,514,838.8
Урьдчилгаа	16,813,885.0	16,116,117.0	(697,768.0)
Бараа материал	133,120,796.8	131,374,972.2	(1,745,824.6)

Төв АЗЗА төрийн өмчит хувьцаат компанийн  
2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Дуусаагүй үйлдвэрлэл	359,653,052.7	328,543,252.7	(31,109,800.0)
Үндсэн хөрөнгө	697,239,465.2	632,927,469.8	(64,311,995.5)
Биет бус хөрөнгө	556,913,000.0	556,913,000.0	-
<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>1,873,819,701.9</b>	<b>2,008,695,179.3</b>	134,875,477.4
Богино хугацаат өглөг	451,951,814.2	552,485,787.2	100,533,973.0
Эздийн өмч	1,421,867,887.7	1,456,209,392.1	34,341,504.4
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>1,873,819,701.9</b>	<b>2,008,695,179.3</b>	134,875,477.4

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 28.0 сая төгрөг болж 68.8 сая төгрөгөөр буурсан нь үйл ажиллагааны зардлын өсөлтөөс шалтгаалсан байна.

Авлага дансны үлдэгдэл 314.8 сая төгрөг болж 301.5 сая төгрөгөөр өссөн нь Тайлант онд санхүүжилт байхгүйн улмаас үүссэн авах авлага 314.8 сая төгрөгөөр нэмэгдсэн нь авлагын өсөлтөд голлон нөлөөлжээ.

Дуусаагүй үйлдвэрлэл дансны үлдэгдэл 328.5 сая төгрөг болж 31.1 сая төгрөгөөр буурсан нь Дархан-Улаан баатар чиглэлийн түр замын 3 дугаар хэсгийн ажил дууссантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 632.9 сая төгрөг болж 64.3 сая төгрөгөөр буурсан нь тайлант хугацааны элэгдлийн зардлаас шалтгаалсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэлд 552.5 сая төгрөгийн төлбөр байна. Өр төлбөр дансанд 2021 онд Төв аймгийн Зуунмод сумын 4 замын тойрог уулзварын ажлыг гүйцэтгэж дууссан боловч санхүүжилт хийгдээгүй, Улаанбаатар Дархан чиглэлийн түр замын ажлыг 2019 онд гүйцэтгэсэн боловч одоог хүртэл санхүүжилт хийгдээгүй зэргээс шалтгаалсан байна.

Санхүүгийн тайланд зардал өртгийн талаарх мэдээллийг бэлтгэх зорилгын дагуу үйлдвэрлэсэн болон борлуулсан бүтээгдэхүүний өртөг, үйл ажиллагааны зардал, үйл ажиллагааны бус зардал гэж ангилсан байна.

Зардал өмнөх онтой харьцуулахад 197.5 сая төгрөг болж 19.1 сая төгрөгөөр нэмэгдсэн нь үнийн өсөлтөөс шалтгаалжээ.

Үйлдвэрлэсэн болон борлуулсан бүтээгдэхүүний өртөгт 1,802.9 сая төгрөг зардалд шууд зардлуудыг хамруулсан байна.

#### 4.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төв АЗЗА ТӨХК-ний 2020 оны 12 дугаар сарын 08-ний 622 тоот тогтоолоор 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 1 902.5 сая төгрөгөөр, нийт зардлыг 1 889.0 сая төгрөгөөр, 37.6 сая төгрөгийн ашигтай байхаар тогтоосон байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 80.0 сая төгрөгийг төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр 2,034.7 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 1,996.6 сая төгрөгийн зардал гарган, 38.2 сая төгрөгийн татварын өмнөх ашиг, 34.3 сая төгрөгийн цэвэр ашигтайгаар ажилласан байна. ТӨБЗГ- 2021 оны 06 дугаар сарын 24-ны 228 тоот тогтоолын дагуу 0.8 сая төгрөгийг бүрэн төвлөрүүлсэн байна.

#### 5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

##### 5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Төв АЗЗА ТӨХК нь тайлант онд нийт 3,385.0 сая төгрөгийн 149 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод, бүрэн байршуулсан байна.

## 5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайлант онд худалдан авах ажиллагааны цахим системд 8 удаагийн 841.8 сая төгрөгийн тендерийн мэдээллээ байршуулж “Худалдан авах ажиллагааны цахим системээр тендер шалгаруулалт зохион байгуулах, холбогдох мэдээллийг зарлан мэдээлэх журам”-ыг мөрдөж ажилласан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт тус тус нийцсэн байна гэж дүгнэлээ.

## 6. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 3.8 сая төгрөгийн төлбөрийн актын биелэлт 100.0 хувь, 15.8 сая төгрөгийн 5 зөвлөмжийн биелэлт 100.0 хувийн биелэлттэй байна.

*Хүснэгт 3. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт /мянган төгрөг/*

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	3,800.0	1	3,800.0			100.0
Зөвлөмж	5	15,800.0	5	15,800.0			100.0
Нийт дүн	6	19,600.0	6	19,600.0			100.0

## 7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тайлант хугацаанд байгууллага дээр ажиллаж хөрөнгийн биет тооллого хийх нөхцөл байдал хязгаарлагдмал байсныг дараагийн тайлант хугацаанд анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

## **8. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 68.7 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 68.7 сая төгрөгийн 3 зөвлөмж өгсөн.

### **8.4 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **1. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал**

##### Илрүүлэлт:

Байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 617.0 сая төгрөгийн хөрөнгө байна. Энэ нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын “Хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох” 7.1-д “төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ” гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

##### Өгсөн зөвлөмж:

Хөрөнгийг байгууллагын өмч хамгаалах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн ТӨБЗГ-аас ашиглах жил, үнэ шинэчлэн тогтоох зөвшөөрөл авч тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх.

#### **2. Бараа материалын данстай холбоотой асуудал**

##### Илрүүлэлт:

Бараа материалын дансанд 64.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бүртгэсэн нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын “Хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох” журмын 2.2. Төрийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй боловч үндсэн хөрөнгийн шинжийг агуулаагүй, элэгдэл байгуулахад тохиромжгүй хөрөнгийг эргэлтийн хөрөнгийн дансанд шилжүүлэх, эргэлтийн хөрөнгөд бүртгэлтэй, үндсэн хөрөнгийн шинжийг агуулсан хөрөнгийг үндсэн хөрөнгийн дансанд шилжүүлэх, үндсэн хөрөнгийн дансны ангилал хооронд шилжүүлэх асуудлыг судлан, тухай бүр зөвшөөрөл олгож байх” гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

##### Өгсөн зөвлөмж:

Хөрөнгийг байгууллагын өмч хамгаалах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн ТӨБЗГ-аас дансны ангилал хооронд шилжүүлэх зөвшөөрөл авч тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх.

#### **3. Зардлын данстай холбоотой асуудал**

Анхан шатны баримтын бүрдэл дутуу 3.0 сая төгрөгийн тэтгэмж, 2.3 сая төгрөгийн сургалтын төлбөрийг зардлаар бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн тайлангийн “иж бүрэн байх”, “үнэн зөв байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

##### Өгсөн зөвлөмж:

Бүрдэл хангасан анхан шатны баримтаар гүйлгээ хийж зардлаар бүртгэх, зөрчлийг давтан гаргахгүй байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 6 дүгээр сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Төв АЗЗА ТӨХК	3	68,700.0							3	68,700.0
	ДҮН	3	68,700.0							3	68,700.0

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум  
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр  
Утас: +976 70272582, +976 70273204  
И –мэйл: [tuv@audit.gov.mn](mailto:tuv@audit.gov.mn), Вебсайт:  
[www.audit.mn](http://www.audit.mn)